

Цагаандэлгэр сумын 2019 оны жилийн эцсийн хүн ам, мал тэжээвэр амьтдын тооллогын дүн

2019 оны жилийн эцсийн хүн, мал тэжээвэр амьтдын улсын тооллого Цагаандэлгэр суманд 12 сарын 07-17-ний хооронд зохион байгуулагдлаа. 2019 оны жилийн эцсийн нийт хүн амын тоо урьдчилсан байдлаар 1073 /Гадаадад амьдардаг 17 иргэн/ үүнээс суурин хүн амын тоо 1056 болж өмнөх оноос 0,19 хувиар буурсан байна. Нийт хүн амын 47,35 хувь буюу 500 нь эмэгтэй 52,65 хувь буюу 556 нь эрэгтэйчүүд байна. Нийт өрхийн тоо 400 болж өмнөх оны мөн үеэс 0,76 хувиар өссөн байна.

Цагаандэлгэр сум 2019 оны жилийн эцэст 152396 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оноос 16732 мянган толгой буюу 12,3 хувиар өссөн байна. Малын өсөлтийг төрлөөр нь авч үзвэл адуу 13,2 хувь буюу 1000, үхэр 10,3 хувь буюу 310, хонь 10,9 хувь буюу 7376, ямаа 14,1 хувь буюу 8046 мянган толгойгоор тус тус өссөн байна. Нийт мал сүрэг 152396 буюу хонь 75090, ямаа 64759, адуу 8568, үхэр 3297, тэмээ 682 болж өссөн байна.

2019 онд 15 малчин мянгаас дээш мал тоолуулж Хараат багийн малчин Ц.Бодьгэрэл, Дэлгэрэх зам багийн аймгийн сайн малчин Б.Батсуурь нар өмнөх амжилтаа баталж, шинээр Хараат багийн малчин Г.Дэлгэрсуурь, Г.Уламбаяр, Э.Отгон-Эрдэнэ, Дэлгэрэх зам багийн малчин Б.Батжаргал, Б.Батхүү, Н.Алтанхуяг, А.Амарбаатар, Жаргалан багийн малчин А.Батмөнх, Д.Гангаамаа, А.Ерөөлт, Замын-Улаан багийн малчин Х.Батбилэг, Т.Өнөрбаян, Н.Баярсайхан нар 1000-с дээш толгой мал тоолуулж сумын хэмжээнд нийт 45 мянгат малчинтай боллоо.

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗДТГАЗАР

